



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/370

Есөнбулаг сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоомж, Засгийн газрын болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилт, тайлан мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажлыг Хэвлэл, эх бэлтгэлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т олгосугай.

2. Гэрээний зардалд шаардагдах 18000000 (арван найман сая) төгрөгийг орон нутгийн төсвийн урсгал зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулан ажлыг чанартай гүйцэтгүүлэн тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Хэвлэлийн алба (Д.Баяраа)-д үүрэг болгосугай.

4. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж хамтарч ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ